



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/527

Булган сум

**Хамтарсан хяналт шалгалт зохион  
байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн XIV/01 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгчдийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, усны нөөцийн ашиглалт, хууль бус ашигт малтмал олборлох зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр хяналт шалгалтын ажлыг 2023 оны 07 сарын 04-өөс 07 дугаар сарын 06-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Хяналт шалгалтын ажлын удирдамжийг 1 дүгээр, шаардагдах зардлын тооцоо, замын маршрутыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хяналт шалгалтын ажилд шаардагдах зардал 1,578,800 (нэг сая таван зуун далан найман мянга найман зуу) төгрөгийг Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хяналт шалгалт хийх, тооллого судалгааны ажил явуулах зардлаас гаргахыг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4. Хяналт шалгалтын ажлыг удирдамж, графикийн дагуу зохион байгуулж, шаардагдах хүн хүч, унаа техникээр тухай бүрд нь хангаж хамтран ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр), Цагдаагийн газрын дарга, (хурандаа Л.Ганбаатар), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА **Б.АРИУН-ЭРДЭНЭ**



Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

**6323030536**

## Хамтарсан хяналт шалгалт хийх ажлын удирдамж

### Нэг. Шалгалтын зорилго

Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Усны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангахад шалгалтын зорилго оршино.

### Хоёр. Шалгалтад хамрагдах хүрээ:

Бүрэгхангай, Дашинчилэн, Баяннуур сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, бичил уурхай эрхлэгч нөхөрлөлүүд хамрагдана.

### Гурав. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа:

#### 3.1. Шалгалтын бүрэлдэхүүн:

-Аймгийн Засаг даргын орлогч Д.Жаргалсайхан ахална. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Л.Ганбаатар, аймгийн ЗДТГ-ын геологи уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын байцаагч Т.Наранцацралт, Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын дарга А.Гантөмөр, тус газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Хос-Эрдэнэ, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Б.Батболд, аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн ажилтан Б.Анхбаяр нар оролцоно.

-Бүрэгхангай, Дашинчилэн, Баяннуур сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Газрын даамал, Байгаль хамгаалагч, Татварын хяналтын улсын байцаагч

3.2. Хяналт шалгалтыг 2023 оны 07 сарын 04-ний өдрөөс 07 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд хяналт шалгалтын ажлыг маршрутын дагуу явуулна.

### Дөрөв. Хийж гүйцэтгэх ажил

4.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн уурхай дээр байх ёстой баримт бичгийн бүрдэл, тухайн жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих

4.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн явц, "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглах гэрээ, усны дүгнэлт, төлбөрийн гүйцэтгэлд хяналт тавих.

4.3. Хууль бус ашигт малтмал олборлох зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авах.

4.4. Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын хэрэгжилтэд хяналт тавина.

4.5 Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих

**Тав. Шалгалтын дүнг тайлагнах**

5.1. Шалгалтаар илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг ажлын хэсгийн бүрэлдэхүүн зохион байгуулж тайлагнана.

Аймгийн Засаг даргын 2023 оны  
 07 дугаар сарын 03 ны өдрийн А/С.Т дугаар  
 захирамжийн 2 дугаар хавсралт



Уул уурхайн хяналт шалгалт хийх замын маршрут

| Д/д | Хяналт шалгалт явуулах чиглэл    | Явах замын хэмжээ (км) | Хугацаа (өдөр) |
|-----|----------------------------------|------------------------|----------------|
| 1   | 2                                | 3                      | * 4            |
| 1   | Булган-Баяннуур                  | 180* /2 машин/         | 1              |
| 2   | Баяннуур-Сант уул                | 60*2 машин             |                |
| 3   | Баяннуур-Туулын гүүр             | 60*2 машин             |                |
| 4   | Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт | 150                    | 2              |
| 5   | Туулын гүүр-Бүрэгхангай          | 45                     |                |
| 6   | Бүрэгхангай-Булган               | 80                     |                |
| 7   | Туулын гүүр-Булган               | 110                    |                |
|     | Нийт                             | 985                    | 3              |

Хяналт шалгалтын ажилд шаардагдах шатахуун, томилолтын зардал  
 (төгрөг)

| Д/д | Хийгдэх ажил      | Тоо хэмжээ                     | Нэг бүрийн өртөг | Нийт өртөг |
|-----|-------------------|--------------------------------|------------------|------------|
| 1   | 2                 | 3                              | 4                | 5          |
| 1   | Шатахуун          | $985 \cdot 18 / 100 = 177,3$ л | 3490             | 618777     |
| 2   | Томилолт хүн/өдөр | $3 \cdot 4 = 12$               | 64000            | 768000     |
|     |                   | $3 \cdot 1 = 3$                | 64000            | 192000     |
|     | Нийт              |                                |                  | 1578800    |

Аймгийн Засаг даргын 2023 оны  
06 дугаар сарын 29-ны өдрийн А/520 дугаар  
захирамжийн хавсралт

**Агентлагийн дарга нарын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн  
төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ**

| Д/д | Агентлагийн нэр                                | Үнэлгээ<br>хувиар | Тайлбар                            |
|-----|--|-------------------|------------------------------------|
| 1   | 2  | 3                 | 4                                  |
| 1   | Онцгой байдлын газар                           | 70.0              | -                                  |
| 2   | Цагдаагийн газар                               | 73.9              | -                                  |
| 3   | Шүүхийн шинжилгээний хэлтэс                    | 66.6              | -                                  |
| 4   | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар                | 67.3              | -                                  |
| 5   | Улсын бүртгэлийн хэлтэс                        | 80.0              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 6   | Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба         | 90.0              | 40 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 7   | Татварын хэлтэс                                | 94.4              | 40 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 8   | Орон нутгийн өмчийн газар                      | 85.6              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 9   | Боловсрол, шинжлэх ухааны газар                | 92.3              | 40 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 10  | Эрүүл мэндийн газар                            | 83.0              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 11  | Хөдөлмөр халамж үйлчилгээний газар             | 81.7              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 12  | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар      | 85.0              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 13  | Нийгмийн даатгалын хэлтэс                      | 90.0              | 40 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 14  | Биеийн тамир, спортын газар                    | 81.0              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 15  | Хүнс, хөдөө аж ахуйн газар                     | 80.6              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 16  | Байгаль орчин аялал жуулчлалын газар           | 71.4              |                                    |
| 17  | Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар | 83.5              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 18  | Мал эмнэлгийн газар                            | 70.2              | -                                  |
| 19  | Статистикийн хэлтэс                            | 81.6              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 20  | Стандарт хэмжил зүйн хэлтэс                    | 82.0              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 21  | Ус цаг уур орчны шинжилгээний төв              | 88.4              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 22  | Соёл урлагийн газар                            | 89.6              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 23  | Эрүүл мэндийн даатгалын хэлтэс                 | 85.0              | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |